

Хяналт шалгалт хийсэн
тухай

Хяналт шалгалтын зорилго

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын баталсан 2017 оны 04 сарын 10-ны өдрийн 1/07 дугаар удирдамжийн дагуу Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон бусад холбогдох дүрэм, журам, тушаалуудын хэрэгжилтийг хангуулж, үндсэн үйл ажиллагааны байдал, зохион байгуулалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны байдлыг шалгаж, ололт амжилтыг бататгаж, зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун
2017 оны 04 сарын 23-ны өдрөөс хуанлын 6 хоног

Шалгалтанд хамрагдсан байгууллагын нэр

Бүрэгхангай сумын “Нарлаг” цэцэрлэгийн 2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаа хамрагдав.

Шалгалтанд хамрагдсан асуудал

- ✓ Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн гаргасан заавар, журам, дүрмийн хэрэгжилтийн байдал
- ✓ Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцэл гаргалт, орлого, зарлагын гүйлгээг үндсэн баримт, бараа материалын тайлан, нягтлан бодох бүртгэлийн журналууд, дансны бичилтүүдтэй тулган шалгах
- ✓ Гадаад, дотоод албан томилолтын зардлын тооцоо бодолтын байдал
- ✓ Орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, данс бүртгэлд тусгасан байдал
- ✓ Байгууллага хоорондын тооцоо өглөг авлага, түүний баталгаажуулалт, бүртгэл тайланд тусгасан байдал
- ✓ Ажиллагсдын цалин хөлс, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн дагуу тогтоож, бодож олгосон байдал
- ✓ Нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлт

- ✓ Өмнөх шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, актын барагдуулалт
- ✓ Дотоод хяналт зохион байгуулсан байдал
- ✓ Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Шалгалтанд хамрагдсан байгууллагын талаарх товч мэдээлэл

Бүрэгхангай сумын дөрөвдүгээр багт байршилтай 9011404 регистрийн дугаартай “Нарлаг” цэцэрлэг нь үндсэн 15 ажиллагсадтай ба үүнээс эрхлэгч 1, арга зүйч дуу хөгжмийн багш 1, үндсэн багш 4, туслах багш 4, тогооч 1, туслах тогооч 1, нярав 1, слесарь 1, үйлчлэгч 1 гэсэн орон тоотойгоор сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг явуулсан байна.

Тус цэцэрлэгийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд 1-р гарын үсгийг Г.Уранчимэг, 2-р гарын үсгийг Б.Батцэцэг нар зурсан ба сумын төрийн санд бүртгэлийн 040315201 тоот, нэмэлт санхүүжилтийн 040315402 тоот данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн ба нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох “СТS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

2016 оны 01 сарын 01-ээс 08 сарын 31-ний өдрийг дуустал Э.Батчимэг, 09 сарын 01-ээс 12 сарын 31-нийг дуустал Д.Саранцэцэг нар няраваар ажилласан байна.

Өмнөх шалгалтын талаар

Булган аймгийн Аудитын газраас тус цэцэрлэгийн 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУСтандарт, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж зөрчилгүй санал дүгнэлт өгчээ.

Шалгалтын явцад хийгдсэн ажил, шалгалтанд хамрагдсан асуудал

Тус цэцэрлэгийн 2016 оны касс харилцахын баримт, эрхлэгчийн тушаал, ажлын цаг ашиглалтын бүртгэл, цалингийн карт, хүнс, бараа материалын тайлан, агуулахын бүртгэл, 2015-2016 он, 2016-2017 оны хичээлийн жилийн багшийн ирцийн бүртгэл, санхүүгийн тайлан, багш ажилчдын 2015 оны 10 сарын 29-ний өдрийн хурлаар шинэчлэн баталсан байгууллагын дотоод журам, 2015 оны 10 сарын 12-ны өдрийн цэцэрлэгийн дотоод хяналт шалгалтын комиссын хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээг цуцлах, гэрээ байгуулах хурлын тэмдэглэл, Бүрэг солонго ХХК-тай улирлаар байгуулсан “Бараа бүтээгдэхүүн худалдан авах” гэрээ, зэрэг баримт материалуудад тулгуурлан эрхлэгч Г.Уранчимэг, нягтлан бодогч Б.Батцэцэг, нярав Д.Саранцэцэг, багш Ж.Бурмаа, Б.Сугар, М.Рагчаасүрэн, Т.Энхтуяа нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

Санхүүжилт, орлогын талаар:

Тайлант онд улсын төсвөөс 186105.7 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж тодотголоор нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлыг 2000.0 мянган төгрөгөөр нэмж, 188105.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтээр

2100.0 мянган төгрөг орж бүгд 190205.7 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Нийгмийн даатгалын сангаас жирэмсэн амаржсан 2 эхийн тэтгэмж 6415.9 мянган төгрөг орсон байна.

Төсвийн тодотголоор нэмэгдсэн 2000.0 мянган төгрөгөөр 100 ш ор хөнжлийн даавууг Орхон аймгийн “Бага тамгын толгой” ХХК-иас, нэмэлт санхүүжилтийн дансаар орсон Орон нутгийн хөгжлийн сангийн 2100.0 мянган төгрөгийн хөрөнгөөр 880.0 мянган төгрөгийн 4 ш багш ширээ, 660.0 мянган төгрөгийн 2 ш төмөр шкаф, 240.0 мянган төгрөгийн 2 ш тортой сандал, 140.0 мянган төгрөгийн 2 ш бандан сандал, 180.0 мянган төгрөгийн самбарыг УБ хотын “Шинэ үе мерси” ХХК-иас худалдан авч, үндсэн хөрөнгийн болон бараа материалын тайланд тусгасан байна.

Төсөвт зардлын талаар:

Төсөвт зардлыг 188105.7 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 187292.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 813.7 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төлөвлөгдсөн зардлаас цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 272.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 198.1 мянган төгрөг, тогтмол зардал 0.18 мянган төгрөг, хангамжийн материал 3.0 мянган төгрөг, хоол 321.7 мянган төгрөг, эм 0.3 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл 1.0 мянган төгрөг, урсгал засвар 6.1 мянган төгрөг, албан томилолт 6.4 мянган төгрөг, төлбөр хураамж 0.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 0.3 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага 0.3 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 2.5 мянган төгрөг, хэмнэгдсэн байна.

Төсвийн нийт зардлын 57.1 хувь буюу 108242.8 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд, 6.2 хувь буюу 11738.6 мянган төгрөгийг ЭМНДШимтгэлийн зардалд, 15.2 хувь буюу 28945.2 мянган төгрөгийг тогтмол зардалд, 16.0 хувь буюу 30359.6 мянган төгрөгийг хоолны зардалд, 1.3 хувь буюу 2506.8 мянган төгрөгийг нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд, 1.1 хувь буюу 2144.6 мянган төгрөгийг бага үнэтэй түргэн элэгдэх зардалд, 0.7 хувь буюу 1431.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд, 0.2 хувь буюу 348.5 мянган төгрөгийг хичээл сургалт үйлдвэрлэлийн дадлагын зардалд, 0.2 хувь буюу 502.8 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд, бусад 7 нэр төрлийн зардалд 0.6 хувь буюу 1072.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Үр дүнгийн урамшуулал, үр чадвар, бусад нэмэгдэл цалингийн талаар:

Булган аймгийн Засаг даргын 2016 оны А/142, А/307, А/451, А/545 дугаар захирамжаар Монгол улсын Засгийн газрын 2013 оны 393 дугаар тогтоолоор баталсан журам, БСШУСайдын 2013 оны А/299 дугаар тушаал, 2014 оны А/60 дугаар тушаалыг үндэслэн эрхлэгчид улирлын ажлын үр дүнг үнэлж 1-4-р улиралд үндсэн цалингийн 45 хувиар тооцон *нийт 1280.2 мянган төгрөгийн* урамшуулалт цалин, аймгийн Засаг даргын 2016 оны 05 сарын 27-ны өдрийн А/257 дугаар захирамжаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 362/112/183 дугаар хамтарсан тушаалаар баталсан журмын 10 дугаар заалтыг үндэслэн эрхлэгчийн 2016 оны эхний хагас жилийн ажлыг дүгнэж

үндсэн цалингаас 20 хувиар тооцож 6, 8, 9,10,11,12 сард *нийт 766.9 мянган төгрөгийн* ур чадварын нэмэгдэл цалин бодож олгожээ.

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2016 оны 07, 18, 25, 28 дугаартай тушаалаар БШУСайдын 2013 оны А/293, 2014 оны А/112 дугаар тушаалыг үндэслэн ажлын үр дүнг нь үнэлж, 1-р улиралд 13 хүнд үндсэн цалингаас 10-40 хувиар тооцож 2091.9 мянган төгрөг, 2-р улиралд 12 хүнд үндсэн цалингаас 10-30 хувиар тооцож 1205.2 мянган төгрөг, 3-р улиралд 14 хүнд үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож 1267.4 мянган төгрөг, 4-р улиралд 14 хүнд үндсэн цалингаас 40-45 хувиар тооцож 2723.7 мянган төгрөг нийт 7288.2 мянган төгрөгөөр урамшуулсан байна.

Эрхлэгчийн 2016 оны 03 сарын 14-ний өдрийн 05 дугаар тушаалаар БСШУСайд, НХХСайд, ССайдын хамтарсан 362/112/183 дугаар тушаал, Байгууллагын дотоод журмын 3.09, 3.10-д заасныг үндэслэн багш Б.Жавзандолгорыг Булган аймагт зохион байгуулагдсан “Би эстрадын дуучин 2016” уралдаанд бүлгийнхээ хүүхдийг 3-р байрт шалгаруулсан амжилтыг нь үнэлж үндсэн цалингийн 10 хувиар тооцож 41.7 мянган төгрөг, багш Б.Сугарыг мэргэжлийн багш нарын ур чадварын уралдаанд 1-р байр эзэлсэн амжилтыг нь үнэлж үндсэн цалингийн 10 хувиар тооцож 53.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл цалин олгосон байна.

Орон нутгийн нэмэгдлийг эрхлэгчид 15 хувиар, багш, туслах багш нарт 10 хувиар үндсэн цалингаас сар бүр бодож 11 хүнд 5207.4 мянган төгрөг, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг “II, III” зэрэгтэй 1 тогоочид 5-10 хувиар үндсэн цалингаас сар бүр тооцож 324.0 мянган төгрөг, заах аргын нэгдэл удирдсаны нэмэгдлийг 2 багшид эхний 5 сард үндсэн цалингаас 5 хувиар тооцож 135.3 мянган төгрөг олгосон байна.

2015 оны 10 сарын 29-ний өдрийн хамт олны хурлаар шинэчлэн баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 5.1-д /Ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуулийн 70.2-д заасны дагуу өдрийн 8 цагаар зохион байгуулна. Ажилчдын ажиллах цагийн хуваариар хүмүүжүүлэгч багш 08³⁰-12⁰⁰, 13⁰⁰ -18³⁰, туслах багш 08³⁰-14⁰⁰, 15⁰⁰ -18³⁰ цаг ажиллана./ заасныг үндэслэн **1-12 сард 8 багш, туслах багшид 18-22 цагийн илүү цагийг үндсэн цалингаас тооцож, 7146.3 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс бодогдсон** байна.

Тэтгэмжийн талаар:

Нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 265.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс эрхлэгчийн тушаалаар багш Н.Удвалд төрж амаржсанд 40.0 мянган төгрөг, багш Ж.Бурмаад түлшний модны хөнгөлөлтөд 90.0 мянган төгрөг нийт 130.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмжийн 6415.9 мянган төгрөгийг 2 багшид олгосон байна.

Хүүхэд өдрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар:

Тус цэцэрлэг нь 2015-2016, 2016-2017 оны хичээлийн жилд бэлтгэл, ахлах, дунд, бага гэсэн 4 бүлэгт 19000 хүүхэд хамруулахаас 17801 хүүхэд өдөр дунджаар 23

хүүхэд, нүүдлийн гэр цэцэрлэг нь 6,7 сард холимог нэг бүлэгт 2 ээлжээр 880 хүүхэд өдөр дунджаар 20 хүүхэд хамруулж нийт хоолны зардалд 30359.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Шалгагдсан онд өглөггүй. оны эцэст хувь хүний орлогын албан татварын 578.0 мянган төгрөгийн авлагатай байна.

Үндсэн хөрөнгийн тайлангаар:

2016 оны эхний үлдэгдэл 160459.8 мянган төгрөгийн хөрөнгө дээр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 5 нэр төрлийн 2100.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, Өрмөн уул ХХКомпани нь цэцэрлэгийн барилгын дээврийн засварын ажлыг 3500.0 мянган төгрөгөөр гүйцэтгэсэн, Фокус металл майнинг ХХК-иас хандиваар өгсөн 135.0 мянган төгрөгийн махны машин, 450.0 мянган төгрөгийн хөлдөөгч, 95.0 мянган төгрөгийн леминатор, 220.0 мянган төгрөгийн дээжийн хөргөгч, 70.0 мянган төгрөгийн нуруулдагч, 420.0 мянган төгрөгөөр өнгөт принтер, 250.0 төмөр сейф, 170.0 мянган төгрөгөөр модон ширээ, 40.0 мянган төгрөгөөр сандал, 122.0 мянган төгрөгөөр модон тавиур, 76.0 мянган төгрөгөөр саарал ширээ, 600.0 мянган төгрөгөөр 24 ш хуванцар шүүгээ, 170.0 мянган төгрөгөөр хивс нийт 2818.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, оны эцэст 168877.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын тайлангаар:

Оны эхний үлдэгдэл 33213.4 мянган төгрөг дээр 4627.0 мянган төгрөгөөр аж ахуйн, 574.5 мянган төгрөгөөр бичиг хэрэг, 1364.8 мянган төгрөгөөр түлш, шатах тослох, 257.9 мянган төгрөгөөр барилгын засвар, 30389.6 мянган төгрөгөөр хүнс, 868.2 мянган төгрөгөөр бусад хангамжийн материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, сумын иргэн Г.Ядамаас хандивласан 2000.0 мянган төгрөгийн хүүхдийн тоглоомыг хүлээн авч, 33892.4 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, цэцэрлэгийн эрхлэгчийн 2016 оны 12 сарын 30-ны өдрийн 30 дугаар тушаалаар ашиглах хугацаа дуусч, шаардлага хангахгүй болсон 18 нэр төрлийн 495.5 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг актлан данс бүртгэлээс хасч оны эцэст 39402.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан баланс гарсан бана.

Сумын иргэн Ч.Баасансүрэнгээс 20 м³ түлшний модыг 700.0 мянган төгрөгөөр худалдан авч, тайлант оны эцэст 455.0 мянган төгрөгийн 13 м³ мод үлдсэн байна. Мөн сумын иргэн Д.Баттулгаас 162.0 мянган төгрөгөөр 6 м³ гишүү худалдан авч нүүдлийн гэр цэцэрлэгт зарцуулсан байна.

Тайлант онд байгууллагын дотор талд урсгал засвар хийлгэхээр иргэн С.Мягмарсүрэнтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж ажлын хөлсөнд 225.0 мянган төгрөг, цэцэрлэгийн гадна тоглоомын талбайн тохижилт хийлгэх, явган хүний зам тавих, хүнсний агуулахын дотор шавардлага хийх зэрэг ажлыг гүйцэтгүүлэхээр сумын иргэн н.Түмэнбаяртай гэрээ байгуулж гүйцэтгүүлэн ажлын хөлсөнд 160.0 мянган төгрөг олгосон байна.

Дээрхи 2 ажлыг гүйцэтгэхэд байгууллагын үндсэн багшаас бусад ажилчид хамтран ажлыг гүйцэтгэсэн байна.

Хүнс, бараа материал нийлүүлэх гэрээний талаар:

2016 онд Бүрэг солонго ХХК-тай хүнс, бараа материал нийлүүлэхээр улирал бүр гэрээ байгуулж, 16337.8 мянган төгрөгийн хүнс, 805.2 мянган төгрөгийн бараа материал авсан байна.

Мах, цагаан идээ, жимс, ногоо, бичиг хэргийн материал зэргийг сумын иргэд, Булган, Орхон аймгаас худалдан авалт хийсэн байна.

Ололттой болон дэвшилттэй тал

✓ 2015-2016 оны хичээлийн жилд бага бүлгийн багш Ж.Энхмаа нь хүүхэд өдрийн болон өдөрт авах хүүхдийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг тогтмол гаргаж хэвшсэн, нийт ирвэл зохих болон ирсэн хүүхэд өдрийн тоо, өвчтэй, чөлөөтэй, тасалсан хүүхдийн тоог бүртгэж дүгнэж, тайлбар тэмдэглэл хийн цэвэр, нямбай засваргүй сайн хөтөлсөн. 2016-2017 оны хичээлийн жилд бэлтгэл бүлгийн багш Б.Сугар нь бүлэгээс бүлэгт, бүлэгээс сургуульд шилжсэн хүүхдийн хөдөлгөөний бүртгэлийг журналд сайн тэмдэглэсэн байна.

✓ Санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд нь гаргаж, аудитаар баталгаажуулсан байна.

✓ Касс, харилцахын баримтууд эмх цэгцтэй үдэгдэж архивлагдсан.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, шалтгаан

1. Анхан шатны баримтуудыг оны эхнээс дугаарлаагүй.

2. 2015-2016 оны хичээлийн жилд дунд, ахлах, бэлтгэл бүлгийн багш нар, 2016-2017 оны хичээлийн жилд бага, дунд, ахлах, бэлтгэл бүлгийн багш нар хүүхэд өдрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг огт гаргаагүй, журналын нийт ирвэл зохих болон ирсэн хүүхэд өдрийн тоо, өвчтэй, чөлөөтэй, тасалсан хүүхдийн тоог бүртгэж дүгнээгүй, дүгнэсэн ч буруу дүгнэсэн, засвартай бүртгэж хөтөлсөн.

3. Хүүхдийн эцэг эхээс нэг хичээлийн жилд бэлтгүүлэх сургалтын хэрэглэгдэхүүн, ариун цэврийн хэрэгслийг авч жагсаалт хөтөлсөн ч материал хүлээлцсэн хүмүүсээр гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй, сургалтын хэрэглэгдэхүүн ариун цэврийн хэрэгслийг эцэг эхээс хагас дутуу бэлтгүүлсэн.

4. Агуулахын бүртгэлийг дэвтэр маягтаар хөтөлж байгаа ч хуудсыг дугаарлаагүй, бүртгэл маягтын баримтын дугаар, хэнд олгож, хаанаас авсаныг бүртгээгүй хагас дутуу хөтөлж байна.

5. Санхүүгийн тайлангаарх бараа материалын үлдэгдэл, тооллогоорх бараа материалын үлдэгдлээс 49.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

6. Хүүхдийн хоолны нормыг насны ангилалаар нь олгоогүй, хоолны өдөрлөгт хэмжих нэгж, нэг хүүхдийн хоолны нормыг тавиагүй.

7. 2016 оны эхний 08 сард ажлын цаг ашиглалтын бүртгэл хөтлөөгүй, цагийн бүртгэлгүй байхад ажлын цагийн тооцоо гаргасан, 01-05 сард 8 багш, туслах багш нарт 18-22 цаг, Соёлын төвийн дуу хөгжмийн багштай гэрээ байгуулан 25-37 цаг ажилласан гэж 4272.9 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг олгосон ч илүү цаг

ажилласныг нотлох баримт, бүртгэлгүй, 09-12 сард багш, ажиллагсдын цагийг ирсэн, явсан цаг минутаар нь бүртгээгүй.

8. Шатахууныг зөвшөөрлийн бичгээр олгодог гэж байгаа ч санхүүгийн баримтанд хавсаргаагүй, авсан шатахууны хэмжээгээр зардалд тусгадаг, жолоочийн тооцоог бодож акт үйлдээгүй, 2016 оны 10 сарын 27-нд НИК ХК-аас 52.5 мянган төгрөгөөр 30 л дизель түлш авсаныг нярав орлогод аваагүй орхигдуулж тайлан гаргасан.

9. Бараа материалд агуулахын бүртгэл хөтөлдөггүй, үндсэн хөрөнгийн тайлан гаргаагүй.

10. Байгууллагын гадна болон дотор урсгал засварын ажлыг гэрээгээр гүйцэтгүүлсэн гэж байгаа ч хүлээн авсан акт үйлдээгүй.

11. Үндсэн хөрөнгийн тайланд тусгагдсан Өрмөн-Уул ХХК-ийн гүйцэтгэсэн 3500.0 мянган төгрөгийн дээврийн засвар, Фокус металл майнинг ХХК-иас үнэ төлбөргүйгээр өгсөн гэх 2818.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тайлан балансад тусгасан боловч анхан шатны баримтын бүрдэлгүй байв.

Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгсөн байдал

- Шалгалтаар бүлгийн багш, туслах багш, санхүү, бүртгэлийн 6 хүнд ирцийн бүртгэл, агуулахын бүртгэл, анхан шатны баримт хөтлөлтийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

- Хүнсний үлдэгдэлд няравыг байлцуулан 2016 оны 04 сарын 24-нд биет тооллого хийлээ. Тооллогоор нарийн гоймон 30 ш байхаас 29 ш, цайны печень 49 ш байхаас 45 ш, эсгэгч 35 ш байхаас 34 ш, шпагетъ гоймон 12 ш байхаас 11 ш, кг гоймон 4.0 кг байхаас 5.4 кг, каш 10 кг байхаас 9.8 кг, гурил 115.9 кг байхаас 130.9 кг, үзэм 7.5 кг байхаас 5.75 кг, мах 403.5 кг байхаас 65 кг байна.

Няравын хувийн тэмдэглэлд 22.025 кг мах Бүрэгбодь дэлгүүрт, 65.4 кг мах дунд бүлгийн багш Э.Батчимэгийн, 61.48 кг мах эрхлэгчийн, 75.9 кг мах бэлтгэл бүлгийн багш Оюунцэцэгийн, 107.3 кг мах ахлах бүлгийн туслах багш Жавзандолгорын бүгд 332.1 кг мах түр хадгалуулсан талаар тэмдэглэл хөтөлсөн байв.

- Улсын байцаагчийн 4 актаар 1510.2 мянган төгрөгийн төлбөр тогтоов.
- Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 8 заалттай 1 албан шаардлага үйлдэв.

Дүгнэлт

Шалгагдсан онуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагааны анхан шатны баримтын бүрдүүлэлт, хөтлөлт хангалттай байна.

Санхүүгийн баримт материалд байгууллага дотооддоо хяналт хийгдээгүйгээс нийтлэг зөрчлүүд илэрч байна.

Цаашид авах арга хэмжээний санал

- Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийг уншиж судлаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх

- Дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

- Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу албан ёсны баримтыг үндэслэн зарцуулж байх
- Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, давтан гаргахгүй байхаар тодорхой ажил зохион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг хангах

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.ОЮУН

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙНЭРХЛЭГЧ
Б.БААСАНСҮРЭНД

Төлбөр хариуцуулан төлүүлэх
тóðàé

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын 2015 оны 06 сарын 16-ны өдрийн 01/06 дугаар удирдамжийн дагуу Хишиг-Өндөр 15-д аааò áàéðëàð “Бялзуухай” цэцэрлэгийн 2013-2014 оны харилцахын баримт, эрхлэгчийн тушаал, ажлын цаг ашиглалтын бүртгэл, цалингийн карт, цалин олгох хүснэгт, агуулахын бүртгэл, багшийн ирцийн бүртгэл, санхүүгийн тайлан, няравын бараа материал, хүнсний тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын газрын дүгнэлт, менежментийн захидал зэрэг баримт материалуудад тулгуурлан эрхлэгч Б.Баасансүрэн, нягтлан бодогч Б.Гэрэлмаа, нярав Н.Чимэгсайхан нарыг байлцуулан 2015 11 06 15-д 21-ээс ажлын 6 хоногт багтаан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

Шалгалтаар нягтлан бодогч Б.Гэрэлмаад бүрэн дунд сургуулийн захирлын шийдвэрээр 2014 оны 1-4 дүгээр улиралд үндсэн цалингаас 45 хувиар бодож 1046.6 мянган төгрөг олгосон байхад цэцэрлэгийн эрхлэгчийн шийдвэрээр 2014 оны 1-4 дүгээр улиралд үндсэн цалингаас 45 хувиар тооцож 1046.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалинг давхардуулснаас 717.0 мянган төгрөгийн урамшуулалт цалинг илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д /Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно./ заасан заалтыг 5-д 1-ий зөрчил илэрлээ.

Монгол улсын “0-дөөí ðýíàèð øàëäàèðóí óóðàé” хуулийн 10.12.2-д /Àæ àðóéí íýäæ, áàéäóóëëäàà, èðäýíëé ðóóëü áóñààð íèñíí ìðëíàí, ýà ð°ð°íàëëä àèð çëëäýæ ðèñíí ìðëíàí áíëäíð, òççí+ëýí áóñààä ó+ðóóëñàí ðíðèðëýä í°ð°í ð°èççýð àñóóàëýä ðíëáíäáíð ðóóëü ðíäòííæëéí äàäóó øèëääýðëýí./ заасан заалтыг үндэслэн 0-1-ий 1-ий:

1. Илүү олгосон урамшуулалт цалингийн 717.0 мянган төгрөгийг эрхлэгч Б.Баасансүрэн, нягтлан бодогч Б.Гэрэлмаа нараар хувь тэнцүүлэн төлүүлж, төсвийн орлого болгосугай.

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙНЭРХЛЭГЧ
Б.БААСАНСҮРЭНД

Төлбөр хариуцуулан төлүүлэх
тöбäé

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын 2015 оны 06 сарын 16-ны өдрийн 01/06 дугаар удирдамжийн дагуу Хишиг-Өндөр һóíúí5-д ääãð ääéðëäð “Бялзуухай” цэцэрлэгийн 2013-2014 оны харилцахын баримт, эрхлэгчийн тушаал, ажлын цаг ашиглалтын бүртгэл, цалингийн карт, цалин олгох хүснэгт, агуулахын бүртгэл, багшийн ирцийн бүртгэл, санхүүгийн тайлан, няравын бараа материал, хүнсний тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын газрын дүгнэлт, менежментийн захидал зэрэг баримт материалуудад тулгуурлан эрхлэгч Б.Баасансүрэн, нягтлан бодогч Б.Гэрэлмаа, нярав Н.Чимэгсайхан нарыг байлцуулан 2015 íú 06 һàðúí 21-ээс ажлын 6 хоногт багтаан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

Шалгалтаар 2013 оны 01 сараас 2014 оны 12 сар хүртэлх хугацааны багшийн ирцийн бүртгэл, жижүүр багшийн хүүхдийн тооны бүртгэл, хүүхдийн хоолны өдөрлөгийг тулган шалгахад бүлгийн багш Г.Долгорсүрэн нь 38 хүүхэд буюу 62.7 мянган төгрөгийн, бүлгийн багш Н.Үүрийнтуяа нь 13 хүүхэд буюу 21.5 мянган төгрөгийн, бүлгийн багш Б.Бурмаа нь 21 хүүхэд буюу 34.6 мянган төгрөгийн, бүлгийн багш Г.Нарантуяань 5 хүүхэд буюу 8.3 мянган төгрөгийн, бүлгийн багш Б.Сарангэрэл нь 16 хүүхэд буюу 26.4 мянган төгрөгийн, бүлгийн багш Т.Оюунболор нь 7 хүүхэд буюу 11.6 мянган төгрөгийн, бүлгийн багш Б.Баасансүрэн нь 1 хүүхэд буюу 1.6 мянган төгрөгийн бүгд 101 хүүхдийг ирээгүй байхад ирсэнээр бүртгэж, 166.7 мянган төгрөгийн хүнсний материал илүү зарлагдсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д /Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно./ заасан заалтыг зөрдөгөөр зөрчил илэрлээ.

Монгол улсын “Ò°ðëéí ðýíàèð øàéäàèòúí óòðäé” хуулийн 10.12.2-д /Àæ äðóéí íúäæ, ääéäóóëäàä, èðäýíéé ðóóëü áóñààð íëñíí îðéíäí, ýä õ°ð°íäèèä äèð çéääýæ óëñúí îðéíäí áíëäíð, ðççí+ëýí áóñàää ó+ðóóëñàí ðíðèðèüä í°ð°í ð°èççéýð àñóóäèüä ðíëáíääíð ðóóëü ðíäòííæèéí ääãóó øèéääýðëýý./ заасан заалтыг үндэслэн ÒÍÃÕÏÕ ÍÛ:

5. Бараа материалын тайланд 175.0 мянган төгрөгийн үнэ бүхий мал тусгагдсан байгаа ч хэдэн насны, хичнээн тооны, ямар төрлийн мал байгаа талаар тайлан, тооцоо байхгүй, малын ашиг шимийн тооцоог боддоггүй.

6. Нэг хичээлийн жилд хүүхдийн эцэг эхээс бэлтгүүлэх сургалтын хэрэглэгдэхүүн, ариун цэврийн хэрэгслийн жагсаалтыг хөтлөөгүй, эцэг эхээс авсан аваагүй нь тодорхойгүй, зарим хүүхдүүдийн эцэг эхээс огт бэлтгүүлээгүй, заримаас нь хагас дутуу авсан, материал хүлээлцсэн гарын үсэггүй, бүлгийн багш нийт ирвэл зохих хүүхэд өдрийг дүгнэхдээ ирсэн хүүхэд өдрийн тоог тавьсан, зарим багш нар өвчтэй, чөлөөтэй, тасалсан хүүхдийн тоог бүртгэдэггүй, ирцийн бүртгэлийг засварласан, ирсэн хүүхдийн тоог буруу дүгнэсэн байна.

7. Ажлын цаг ашиглалтын бүртгэлд цаг бүртгэгчийн гарын үсэггүй, батлагдсан маягтыг бүрэн хөтлөөгүй нь Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралтаар баталсан “Хөдөлмөр цалин хөлсний маягтын нөхөх заавар”-ын 4.1-д заасан заалтыг зөрчсөн зөрчил илэрлээ.

Èëìà Ìííàíë òëñíí Ò°ðëéí ðÿíàëò ðàëäàëòòí òòòàé òóóëëéí 10 äöäààð ç¿éëëéí 10.9.8-ä /Ïÿíàëò ðàëäàëòòíí ÿâöàä èëÿðñÿí ç°ð+èë äóòàäàëüä òàñëàí çíàññò, ò¿¿íëé ðàëòàààí í°ò°ëëëä äðëëäàð òàëààð òíëáíäáíð äàëäóóëëäàà, àæ äòóé íÿæ, ïðãýí, àëààí òóòàäëòàíä ðààðàëäàà òàäüæ, òóäàòààòàé¿¿ðÿ äààëäààð °ä+ äëäëÿëòëëä òáíäóóëäð/ çàäààñàí ä¿ðÿí ÿðòëéíÿÿ äàäóó ØÀÄÄÄÖ ÍÛ:

1. Аíðàí ðàòíü äàðëèòóóäÿã îíÿ èõíээс дугаарлаж, баримтын ä¿ðàëëëäòòòàé ä¿ðää íü ä¿ðÿí ä¿éòÿð ä¿ðä¿¿ëëэн гарын үсгийн бүрдлийг хангуулж, агуулахын бүртгэлийг тухай бүр хөтлөх

2. Бараа материалын тайланг батлагдсан маягтын дагуу нэр төрлөөр нь сар бүр гаргаж, хянуулж баталгаажуулах

3. Түлээ, нүүрсний тайланг сар бүр гаргаж, зарцуулахдаа тухай бүр нь шаардах хуудсаар тавьж олгох, хүлээн авахдаа акт үйлдэх

4. Шатахууныг няраваар дамжуулан жолоочийн тооцоог бодож, шатахууны хэтрэлт, хэмнэлтээр тооцон акт үйлдэх

5. 175.0 мянган төгрөгийн үнэ бүхий малын хэдэн насны, хичнээн тооны, ямар төрлийн мал байгааг нүд үзэн тоолж, акт үйлдэн албан тоотой хугацаанд нь хариуг ирүүлэх

6. Хүүхдийн эцэг эхээс сургалтын хэрэглэгдэхүүн, ариун цэврийн хэрэгслийг бүрэн бэлтгүүлж, жагсаалтыг тухай бүр хөтлөж, материал хүлээлцсэн гарын үсгийг зуруулж баталгаажуулах, бүлгийн багш нар ирцийн бүртгэлийн хүүхэд өдөр, хүүхдийн тооны нийт дүнг зөв дүгнэж, багшийн журналыг засваргүй үйлдэх

7. Ажлын цаг ашиглалтын бүртгэлд цаг бүртгэгчийн гарын үсгийг тухай бүр зурж, батлагдсан маягтыг бүрэн хөтлөх

Àëààí ðààðàëäààí äëäëÿëòëëä 2015 íü 07 ñàðòí 25-íü àíðòð àëíäëéí Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанд àëààí òíòíð èð¿¿ëÿòëëä íÿÿäüä.

Àëààí ðààðàëäààí òóòàòàíä íü äëäë¿¿ÿÿ¿¿é, òàðëò èð¿¿ëÿÿ¿¿é òíòëíëäíëä “Ò°ðëéí ðÿíàëò ðàëäàëòòí òòòàé òóóëü”-ëéí 16.1.2 äàòü àíëí òíëáíäáíð áóñàä òóóëëéí äàäóó òàðëòòëäàä ò¿ëÿÿäÿõÿíã мэдэгдэж байна.

БИЧСЭН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ
Ж.ОЮУН

ХҮЛЭЭН АВСАН:
ХИШИГ-ӨНДӨР СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.БААСАНСҮРЭН
НЯ-БО Б.ГЭРЭЛМАА
НЯРАВ
П.ЧИМЭГСАЙХАН

